

Living the LOTUS

Buddhism in Everyday Life

11
2018

VOL. 158



Үүсгэн байгуулагчийн сургаал

Тангараг өргөхийн ач холбогдол

Хүн гэдэг сул дорой амьтан бөгөөд сайн үйлийг хийх ёстой гэж мэдэж байгаа хэрнээ залхуу сэтгэлдээ дийлдэж орхих нь олон.

Үргэлж модон дээр завиан суудаг “Шувууны үүр” хэмээн нэрлэгддэг Зэн урсгалын мастер Даолинаас тухайн бүс нутгийн ахлагчаар томилогдоод байсан Бай Жүи ингэж асуусан гэдэг. “Бурханы сургаал гэж ямар сургаал юм бэ?”. Даолин мастер: “муу үйлийг тэвчиж, сайн үйлийг хийж сэтгэлээ ариусгах нь бурханы сургаал болой” хэмээх алдартай хариултаа тухайн үед хэлсэн гэдэг. Тэгэхэд Бай Жүи “3 настай хүүхэд ч мэддэг л зүйл байна даг” хэмээн ам асуухад Даолин мастер “3 настай хүүхэд хүртэл мэддэг зүйлийг 80 настай буурал хүртэл үл чадна” гэж хариулсан гэдэг.

Хүмүүс бид энэ сул талаа явал дийлэх вэ? Энэ үед номын андуудын хэрэг гарна. Зөвхөн сэтгэлдээ бодоод байх бус олон номын анд нарынхаа өмнө амлалт өгөх. Үүнийг тангараг гэж хэлээд байгаа юм.

Шашин шүтлэгт сэтгэлээ өөрчлөх чухал гэж хэлдэг боловч ганцаараа үүнийг хийж чадах хүн тийм ч олон биш болов уу. Тиймээс олны өмнө зориг гарган тангараг өргөсөн номын андынхаа бурханлаг чанарт итгэж, бага зэргийн алдаа гаргасан ч уужим хандаж, дэмжсээр байх хэрэгтэй. Энэхүү дэмжлэг, итгэл найдварыг алдаж болохгүй гэсэн эрмэлзэл л хүнийг өөрчилдөг юм.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, 122-123

Living the Lotus
Vol. 158 (2018.11)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б. Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

**“Бусдыг бодох, энэрэнгүй байх”
СЭТГЭЛИЙГ ТЭЭХ НЬ**

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Амар амгалан” бол “зөв” байгаа үе

Гадаа сэрүүсч, Японы хувьд халуун рашаанд ороход сэтгэл сэргэж, бие амрах сайхан үе ирээд байна. Онгоц дүүрэн халуун усанд орж булхангаа өөрийн мэдэлгүй “ай даа диваажин гэж л энэ байх даа” гэж амандаа буйтнах тэр мөчид амар амгаланг мэдрэх хүн олон бизээ.

Сэтгэл амгалан тайван, баяр баясалтай байвал усанд орж байх үе ч бай, өөр зүйл хийж байсан ч бай бидний сэтгэл зүрх тухайн мөчид түгшүүр, үзэн ядалт зэргээс ангижирсан байдаг. Тэр үед бид төөрөгдөл, автах сэтгэлээс ангижирч, юунд ч хүлэгдээгүй, амар амгалан өөдрөг хүн болсон байдаг.

“Бурхан” гэдэг үгний ханзгийг Япон хэлээр “хотокэ” гэж дууддаг ба үгний язгуур нь автах хийгээд хармын сэтгэлийн хүлээснээс тайлагдсан гэсэн утгатай “ходокэрү” гэдэг үгнээс гаралтай. Тиймээс хормын төдийд ч гэсэн амар амгалан, юунд ч санаа зовох зүйлгүй болох тэр үе бол янз бүрийн хүлээснээс ангижирсан “бурханы түвшин”-д хүрсэн үе гэж хэлж болох болов уу.

Бурханы сургаалд “сэтгэлээ үргэлж зөв чиг лүү жолоодох” нь чухал гэж сургадаг. Энэ нь Бурхан багшийн хамгийн анх шавь нартаа айлдсан “Хутагтын найман мөр”-н 7 дугаарт дурьдагддаг “зөв хандлага”-г хэлж байгаа юм.

Гэвч “зөв чиг нь аль вэ гэдгийг мэдэхгүй байна” гэх хүн олон байгаа гэж бодно. Товчхондоо бол “бурхан” хийгээд “үнэн, ном” луу сэтгэлээ чиглүүлэхийг зөв чиг гэж хэлж байгаа боловч энэ ч гэсэн ойлгоход бэрх байна гэх хүн байж магадгүй. Миний хувьд дээр дурьдсан “сэтгэл зовинох зүйлгүй, амгалан тайван, баяр баясалтай байх үе”-ийг сэтгэл зөв чигтээ байна гэж хэлж болох шиг санагдаж байна.

Харин ганц хором бус “байнга, үргэлж” зөв зүгт сэтгэлээ залж чаддаг болмоор байна гэвэл өөр зүйл ярих хэрэгтэй болно.

“Аврах юмсан” гэж хүсэх төдийд

Лянхуан гурамсан судар-н “Иж Бүрний билигт Бодисадвагийн даяны бүтээл судар”-г “ямагт нирваанд оршин амгалан баясаж Амар тайван байхыг хүсвээс” (янз бүрийн төөрөгдөл, мунхагаас салж, амар тайван, баяр баясалтай байхыг хүсвэл) гэсэн бидний хувьд хамгийн мэдэхийг хүсдэг хэсэг байдаг.

Хариулт нь “их хөлгөний судар Сүсэглэн уншиж бодисадва нар дор мөргөмүй.”. Өөрөөр хэлбэл өглөө, оройн судар уншлагыг хэвшил болгож “энэрэл нигүүлсэл, бусдыг бодох сэтгэлийг тээж амьдаръя” гэсэн үг юм. Энэ нь үргэлж сэтгэл амгалан, баяр баясалтай амьдрах арга бөгөөд ялангуяа гишүүн болсон бидний хувьд хамгийн ойрын хэрэгжүүлэлт гэж хэлж болно. Түүнчлэн “бусдыг бодох сэтгэлийг тээ” гэсэн тушаах хэлбэр биш “бусдыг бодох сэтгэлийг тээж амьдрах нь чухал” гэхээр хүлээж авахад ч хялбар.

Хааяа “энэрэл нигүүлсэлийг тээж чадахгүй байна, хэвшил болгож чадахгүй байна” хэмээн гутрах хүн байдаг. Гэвч тэр хүнд “бусдыг бодох сэтгэлийг тээж амьдаръя”, “тэр хүнийг аврахсан, туслахсан” гэсэн хүсэл байгаа учраас л ийнхүү гутарч буй хэрэг. Өөрөөр хэлбэл тэр хүнд аль хэдийн бусдыг бодох сэтгэл үндэслэсэн байна гэсэн үг юм.

Хэдий тийм байлаа ч хэнд ч сэтгэлээ жолоодож чадахгүй, олон бодолд дарагдаж төөрөлдөх үе байдаг. Тийм үед Озаки Хоосай-н нэг мөртийг санахад тустай байж магадгүй.

“Вандуйг хальснаас нь салгах шиг хүнийг буруутгах сэтгэлээ гээцгээе”

Уур бухимдал, шуналдаа автах гээд байвал эхлээд яг одоо хийх ёстой зүйлдээ төвлөрч, өөрийгөө тэр ажилдаа бүрэн зориулах. Энэ нь “зөв хандлага”-ыг бий болгох нэг арга гэж хэлж болно.

Мөн “зөв хандлага”-н утгыг “анзаарах”, “бусдад санаа тавих” зэргээр тайлбарлах хүн байдаг. Японы цайны урлагийн Үрасэнкэ сургуулийн өв залгамжлагч 15-р Сэн Сошицү багштан: “<таныг аз жаргалтай болгоё> гэсэн цорын ганц бодлоор цайг бэлдэх нь чухал” гэж сургасан байдаг. Илүү дутуу бодлоо гээж, яг одоо хийж буй зүйлдээ бүрэн төвлөрөх. Улмаар өөрийнхөө үзэл бодлоо түр азнаж, бусдад аз жаргал, баяр баяслыг дотроо хүсэнгээ сэтгэлээ нэг зүйлд төвлөрүүлэх. Энэ ч гэсэн “зөв хандлага” юм.

“Зөв хандлага” нь “Хутагтын найман мөр”-н хамгийн чухал хэрэгжүүлэлтийн хэсэг. Бусдын сайн сайхныг бодсон сэтгэлээс үндэслэсэн амар амгалан, баяр баяслыг өөртөө хэвшүүлж, эзэмших үед дараагийн “зөв бясалгал”-г хэрэгжүүлэхэд жинхэнэ утгаараа ач буяныг нь мэдрэх болно.

“Косей” сэтгүүл 11-р сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Үлгэрлэл 3-р бүлэг

ЦЛС нь энэ бүлгээс агуулгын хувьд ойлгоход туйлын хялбар болно. Учир нь Шагжамүни бурхан багш онолын, гүн ухаанлаг айлдвараа гэнэт өөрчилж, энэ бүлгээс үлгэр домгийг түлхүү ашиглаж сургаалаа айлдах тул энгийн хүмүүст ойлгоход хялбар болно.

Эш үзүүлэх

2-р бүлэг “Уран арга”-н айлдварыг сонссон Шаарийбуу баярын мишээл тодруулж, харайн босоод “Бурхан багшаа таны айлдварыг сайн ойлголоо, баярлалаа. Үүнээс илүү баяртай зүйл гэж үгүй билээ” гэж талархалаа илэрхийлнэ.

Шаарийбуу яагаад ингэж их баярласан бэ гэхээр өөрийгөө ч бурханы хутгийг олж гэгээрч болох юм байна гэдгийг тодорхой ойлгосон учраас юм. Шаарийбуу нь өдийг болтол өөрийгөө ширваган гэж бат итгээд, ширваган бол бодисадвагийн хэмжээнд хүрэхгүй бясалгагч хэмээн бодисадва, ширваган хоёрын хооронд зураас татан тусгаарлаж боддог байв. Улмаар Бурхан будда нь хүрэхийн аргагүй өндөр оршихуун тул өөрийгөө тэр түвшинд хүрэх болоогүй гэж үзээд, будда болох талаар бодож ч зүрхэлдэггүй байж.

Гэтэл Бурхан багш “Уран арга”-ын айлдвар дотор “Олон хөлгөн гэж байхгүй, зөвхөн Бурханы хөлгөн гэж л байгаа (Бурханы зам мөрт хоёр эсвэл гурав гэж байхгүй, зөвхөн ганцхан бурхан болох зам байгаа) хэмээн айлдаад, “миний шавь нар бүгд бодисадва бөгөөд ширваган гэж байхгүй

болой” гэж тунхаглаад, төгсгөлд нь “Сэтгэлд их хөөр баяслыг төрүүлээд, Өөрийгөө магад Бурхан болмуй хэмээн мэдэгтүн” гэж бататган хэлдэг. Үүнийг сонсоод өөрийгөө Ширваган гэдэг ахлах сургуульд сурч байгаа гэж бодож байтал үнэндээ тэр сургууль нь бодисадвагийн их сургуулийн бэлтгэл анги байсныг ухаардаг. Улмаар бодисадвагийн их сургууль нь бурхан будда болгодог их сургууль тул дияан бясалгал, үйлийг сайн хийвэл эргэлзээгүй бурханы хутгийг олж чадна гэдгийг маш сайн ойлгосон байна. Тиймээс баярлахгүй байхын аргагүй.

Шаарийбуу бурхан багшид талархалаа илэрхийлэхийн далимд, өөрийнхөө буруу бодож явснаа наминчилдаг. Тэгмэгц бурхан багш Шаарийбуугийн ухаарал зөв гэдгийг хүлээн зөвшөөрөөд “чи бээр эргэлзээгүй бурханы түвшинд хүрч чадна” хэмээх баталгааг өгдөг. Энэ нь ширваган шавь нараас хамгийн анх эш авсан тохиолдол юм. Үүний дараа бурхан багшийн их шавь нар ар араасаа бурханаас эш авах бөгөөд эцэст нь бүх шавь нар бурхан болох эш авдаг байна. Тиймээс “Цагаан лянхуа судар нь Эш үзүүлснийг үгүүлэх судар” гэж ч хэлж болно. Өөрөөр хэлбэл “бүх хүн бурханы хутгийг олж чадна” хэмээх баталгааг өгсөн судар гэж хэлж болно. Энэ нь Цагаан лянхуа судрын хамгийн том онцлог юм.

Ийнхүү талархал илэрхийлж, наминчлал хийсэн Шаарийбуу нь “би бурханы гэгээрлийн түвшинд заавал хүрэх болно. Түүнчлэн эрхэм дээд сургаалыг айлдаж, олон хүнийг бурханы зам мөрт оруулах болно” хэмээн тангараглаад, “би бээр бурхан багшийн айлдварын буянаар нүдээ нээж чадсан боловч өөр олон хүн бурханы сургаалыг дэндүү хол, дэндүү гүн гүнзгий тул хүрэх аргагүй хэмээн эргэлзээ тээж байна. Тэрхүү хүмүүст ч ойлгоход хялбараар дахин айлдаж болгоохтун” гэж гуйдаг.

Тэгэхэд Шагжамүни будда “гурван тэрэг ба шатаж буй байшин” үлгэрийг ярьдаг.

Гурван тэрэг ба шатаж буй байшингийн үлгэр

“Эрт урьд цагт нэгэн улсад баян хангалуун ноён амьдран суудаг байжээ. Орд гэр нь маш уужим том боловч ганцхан хаалгатай ба тэр хаалга нь давчуу жижигхэн ажээ. Түүнчлэн ордны доторх нь ундуй сундуй, эмх замбараагүй. Гэнэт ордонд гал гарчээ. Нүд ирмэхийн зуур гал газар авав.



Ордонд ноёны хүүхдүүд олноороо тоглож байлаа. Гадаа байсан ноён эргээд хартал хүүхдүүд нь тоглоомондоо улайраад гал гарсныг анзаарах сэхээгүй байв.

Гал гарч байхад анзаарахгүй, улмаар зугтан амь гарахыг ч хичээхгүй байлаа. Ноёнтон тэр үед ингэж бодов. Би хүүхдүүдийг бүгдийг нь өргөж даах чадалтай тул том хайрцаг олоод бүгдийг нь суулгаад авч гарвал амь аврагдах болов уу. Гэвч дахин сайн бодлоо. “Байз, хүчээр аваад гарах гэхэд дүргүйцэх хүн байж таарна. Тийм хүнийг аваад гарах гэтэл дүргүйцэн тийчигнэж байгаад галд унаад үхэж ч мэднэ. Тиймээс галын аюулыг мэдэгдэж, өөрсдийнх нь хөлөөр гаргаж ирэх нь хамгийн зөв юм байна” гэж бодов.

Ноён хүүхдүүдэд хандаж, чанга дуугаар “Наана чинь гал гарч байна, аюултай шүү, хурдан гадаа гараарай” гэж хашгирсан боловч хүүхдүүд ноёны царай луу хааяа нэг харахаас хэтэрсэнгүй. Тэгтэл ноён хүүхдүүдээ тэргэнд дуртай ба тэрэгтэй болохыг хүсдэгийг нь гэнэт санав. “Та нарын дуртай хонин тэрэг, буган тэрэг, үхэр тэрэг бүгд энд ордны гадаа байна. Хурдан гарч ирээд дуртайгаа аваарай” гэж хашгирав.

Хүүхдүүд тэр үгийг сонсмогц ухаан орж, “хурдан тийшээ явъя” гэцгээн бие биетэйгээ уралдан шатаж буй байшингаас гарч чадав. Эцэг ноён хүүхдүүдээ гэмтэж бэртэлгүй байшингаас гарч ирсэнд сэтгэл нь амрав. Эцгийгээ харсан хүүхдүүд амласан тэрэг нь хаана байна хэмээн ам уралдан асуув. Тэгтэл ноёнтон хүүхдүүдийнхээ хүсэж байсан тэргийг биш, харин түүнээс ч илүү үлэмж том цагаан үхэр хөлөглөж, эрдэнийн чулуугаар чимэглэсэн сүрлэг сайхан тэргийг хүүхэд бүртээ өгөв.”

Энэ үлгэрийн цаад утгыг товчхон тайлбарлавал эцэг ноёнтон нь Бурхан юм. Хүүхдүүд нь жирийн хүмүүс болох биднийг хэлж байгаа. Эмх замбараагүй байшин бол одоогийн бидний амьдарч байгаа нийгэм. Гал түймэр нь бидний сэтгэлийн гэм, мунхаглалыг хэлж байгаа юм. Хүний амьдралд тохиолдох зовлонгийн гол шалтгаан нь сэтгэлийн гэм буюу нисваанис байдаг. Эд баялаг, махан биендээ хэтэрхий автаж шунаснаас болж оюун ухааны эрх чөлөөгөө алддаг учир зовж шаналдаг байна. Өөрийнхөө оюун ухаан эрх чөлөөгүй байгааг ч анзаардаггүй мунхаг хүмүүс олон бий. Тиймээс мунхагийн түймэрт шатах гэж буйгаа ч мэдэхгүй зөвхөн өнөөдрөө л болгож байвал

болоо гэх хүн цөөнгүй байдаг.

Хүмүүсийн энэхүү азгүй байдлаас нь авран гаргахын тулд Шагжамүни Бурхан багш янз бүрийн сургаалыг айлдсан билээ.

Хүмүүс дотроо олон төрөлд хуваагддаг ба авралын замаар явахдаа сайн сургаалыг нэгэн сэтгэлээр сонсож, төөрөгдлөөсөө салахыг эрмэлздэг сонсохыг чухалчлагч Ширваган нар байхад ганцаараа бясалгал, дияан хийж, эрэл хайгуул хийснээр зам мөрийг нээх хүсэлтэй учралыг чухалчлагч Брадигабуда нар, мөн дээдийн гэгээрлийг хүсэмжлэхийн зэрэгцээ хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэхийн төлөө зүтгэлэг бодисадва гэж байдаг. Хүмүүс Шагжамүни бурхан багшийн сургаалын дотор өөрийн онцлогт таарсан зүйл байвал өөрийн мэдэлгүй тэрхүү сургаалд татагдан ордог байна. Хүүхдүүд тус бүртээ хүссэн тэргээ авахын тулд өөрийн хүчээр гадагшаа гүйн гарсан гэдэг нь ийм учиртай бөлгөө.





Бурханы сургаал цорын ганц

Тиймээс Бурханы сургаал эцсийн дүндээ “Будда болох зам” гэсэн ганц л зам байгаа боловч түүний бэлтгэл шат болгож янз бүрийн “уран аргын сургаал”-г айлддаг байна. Хүмүүс өөр өөрийн сургаалын дагуух замаар сэтгэлээ сайжруулахын төлөө хамаг чадлаараа хичээх бөгөөд тэрхүү үйл нь дээшилж шат ахих тусам замууд нийлж эцсийн бүлэгтээ бүгд нэг зам болж байгааг ойлгох болно. “Будда болох зам” гэж үүнийг хэлээд байгаа юм. Өдийг болтол явж ирсэн өөрийн замыг 2-р, 3-р зэрэглэлийн зам гэж андууран бодож байсан бол үнэндээ бүх зам дээдийн дээд үнэний замтай нийлсэн нэг зам байсныг мэдээд сэтгэл нь амарч, хийж бүтээх хүсэл эрмэлзэл төрж, баяр хөөрийг мэдрэх болно. Хонин тэрэг, буган тэрэг, үхэр тэрэг л авах талаар бодож байсан хүүхдүүд сүрлэг цагаан үхэр тэрэг гэсэн төсөөлж ч байгаагүй дээд зэрэглэлийн тэрэг (будда болох зам) –г бүгд ижил тэнцүү хүртээд баярлан хөөрсөн гэдэг нь ийм учиртай юм.

Энэ үлгэрийн хэсэг бүрийг харьцуулж уншвал дээрхийн адил чухал утга өшөө ч олон байгааг мэдэх болно.





«Бусдыг бодох» сэтгэлийг тээх нь


11 сар бол Үүсгэн байгуулагчийн мэндэлсэн сар юм. Жилд тохиодог талархалтай үе билээ. Энэ үеэр үүсгэн байгуулагчийн ач буянд талархаж, бодисадвагийн үйлийг хэрэгжүүлж, хойшдын үйл хэргээ шинээр тангараглах үе ч гэж хэлж болно.

Бодисадвагийн үйлийн дотроос хамгийн чухал нь “өргөлийн үйл” юм. Бүгдээрээ Үүсгэн байгуулагч, түүнчлэн Сургаал номын ачаар одоогийн аз жаргалыг хүртээд буйдаа талархаж эдийн өглөг өргөцгөөе. Бүтэн жил Бурханы ивээлд багтсанд талархаж, мөн 80 жилийн ойн баярт зориулан сэтгэлээ шингээн өргөл өргөвөл ямар вэ?

Түүнчлэн Цагаан Лянхуан судрын сургаалтэй учирснаар “надтай” ижил аз жаргалтай болох хүн илүү олон болох болтугай гэсэн сэтгэлээр сургаал түгээлтийн ариун үйлсэд зүтгэж, гишүүд элсүүлэх нь ч өргөлийн үйлийн нэг хэлбэр бөгөөд гайхалтай бодисадвагийн үйл билээ.

Хүмүүсийн төлөө, дэрхийн эв найрамдлын төлөө насаараа зүтгэсэн Үүсгэн байгуулагчаас суралцаж, бусдын төлөө гэсэн сэтгэлээр бодисадвагийн үйлд шамдацгаая!

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



🌸 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌸

✉ Welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437
e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX78269, USA
Tel: 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951
e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento
Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com
<http://home.earthlink.net/~rkchi/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi
110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai